



## ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2017 оны 05 дугаар сарын 24

Дугаар 03

Мандалговь хот

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дүгээр зүйлийн 42.1 дахь заалтын дагуу "Үнэн анд" ХХК (цаашид "Компани гэх)-аас тухайн аймгийн Мануулт серег нөлөө багатай үйл ажиллагаа явуулах болон орон нутгийн нийгэм, здийн засгийг хөгжүүлэхэд бодит оролцоог бий болгох, ажлын байр нэмэгдүүлэхэд зохих дэмжлэг үзүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар харилцан тохиорлцож энэхүү гэрээг байгуулав.

1.2. Энэ гэрээнд Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай хууль, Цемийн энергийн тухай хууль, Газрын тухай хууль, Газрын хэвлэлийн тухай хууль, Байгаль орчны тухай хууль болон бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

1.3. Энэхүү гэрээ холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд Дундговь аймгийн "Ашигт малтмалын талаар аймгаас баримтлах бодлого", "Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр"-үүдийг үндэслэн нэг талаас Дундговь аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Н.Эрдэнэ-Очир /цаашид А тал гэх/ негее талаас "Үнэн Анд" ХХК-ний /улсын бүртгэлийн дугаар 9011038138, РД 2885565 / захирал Т.Төмөрсоль /Цаашид Б тал гэх/ нар байгуулав.

1.4. Энэхүү гэрээ нь байгуулагдсанас хойш 1 /нэг/ жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

### Хоёр. А талын хүлээх эрх, үүрэг

2.1. Б талд ашигт малтмалын орд газрыг ашиглах үйл ажиллагаа явуулахад холбогдох хууль, дүрэм журмын хүрээнд сум, орон нутгийн зүгээс шаардагдах бүхий л үйлчилгээ, дэмжлэг туслалцааг үзүүлэх.

2.2. Ашигт малтмалын ашиглалтын үеийн аюулгүй байдлыг хангах, үйл ажиллагаа явуулах хэвийн орчин, нөхцлийг бүрдүүлж өгөх.

2.3. Б талаас аймаг, сумын хөгжилд оруулсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус (мөнгөн болон бусад хэлбэрээр) дэмжлэг, туслалцаа, хөрөнгө оруулалтын талаарх үнэн зөв мэдээллийг шаардлагатай тохиолдолд компанийн зөвшөөрөлтэйгээр сонирхсон этгээдэд гаргаж өгөх буюу орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн дамжуулж нийтэд мэдээлэх.

- 2.4. Ашигт малтмал олборлох үйл ажиллагааг байгаль орчинд аль болох серег нелөөгүй технологиор явуулахыг дэмжих, олборлолтын үйл ажиллагаа явуулсны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажилд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавих
- 2.5. Аймаг, сумын хөгжилд оруулсан хөрөнгө оруулалт, хандив дэмжлэг туслалцаат төрийн сангаар дамжуулан авч, зарцуулалтыг жил бүр тооцож тайлан мэдээнд оруулан нээлттэй ил тод мэдээлэх
- 2.6. Ашигт малтмалын салбарын тухайн жилийн "Байгальд зэлтэй шилдэг" аж ахуйн нэгжийг шалгаруулж, алдаршуулахад тухайн компаний үзүүлэлтийг харьцуулан үзэж байх

#### Гурав. Б талын хүлээх эрх, үүрэг

- 3.1. Орон нутгийн
- 3.2. төсөөт хуулиар хүлээсэн татвар, хураамжийг төлж, тайлан, мэдээг сум, аймгийн Татварын хэлтэст гаргаж өгч байх / ААНОАТатвар, ХАОАТатвар, АТӨЯХ-ийн албан татвар, нийтмийн даатгал, ЭМДаатгал болон газар, ус ашигласны төлбөр/
- 3.3. Олборлох үйлдвэр байгуулахдаа байгаль орчныг хамгаалах арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх
- 3.4. Олборлосон хүдрийг тээвэрлэхдээс аймгаас баталсан ашигт малтмал тээвэрлэх замын маршрутын дагуу тээвэрлэх. Цаашид хүдрийг хатуу хучилттай автозамаар тээвэрлэхээр тооцож, зураг, төсвийг хийлгэх, бусад ашигт малтмал олборлогч компаниудтай хөрөнгө нийлүүлж, зам барих асуудлыг шийдэх
- 3.5. Олборлосон хүдрийн тээвэрлэлтийг шаардалга хангасан орон нутгийн тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг иргэд, аж ахуйн нэгжтэй гэрээнл гүйцэтгүүлэх
- 3.6. Уурхайн үйл ажиллагаатай холбоотой аливаа ханган нийлүүлэлт /мах, сүү, цагаан идээ, ажлын хувцас, багаж хэрэгсэл, харуул хамгаалалт гэх мэт/- ийг орон нутгийн малчин, үйлдвэрлэгч, аж ахуйн нэгжүүдээс авч байх
- 3.7. Ажлын байрны шаардлага хангасан тохиолдолд нийт ажиллагсадын 60%-иас доошгүй хувийг орон нутгийн иргэдээс авч зохих түвшний ажиллуулах
- 3.8. Нийт ажиллагдын 10%-иас илүү тооны гадаадын иргэн ажиллуулсан тохиолдолд Ашигт малтмалын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2-т заалтын дагуу 43 дугаар зүйлийн 43.1 /тухайн хуулийн эзээлдээд ажиллагдын 10-аас дээшгүй хувь нь гадаадын иргэн байж болно/ зааснаас илүү хэмжээгээр авч ажиллуулсан тохиолдолд ажлын байр тутамд хөдөлмөрийн хөлслний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг сар бүр орон нутгийн төсвэти төлөх
- 3.9. Мен иргэний бүртгэлийн тухай хуулийн 26.4 дэх заалтын дагуу өөр орон нутагт харьяалагддаг иргэдийг 180-аас бага хоногоор тухайн аймагт ажиллахад түр оршин суугчаар бүртгүүлэх
- 3.10. Аймаг, сумаас ажилд авсан иргэдтэй Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хөдөлмөрийн гэрээ байгуулж, цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийг төлөх
- 3.11. Энэхүү гэрээний хүчинтэй байх хугацаанд Б тал 10 000 000 /Арван сая/ төгрөгийн дэмжлэгийг их номч, түүхч гун ухаантан, нэрт соён гэгээрүүлэгч Зава хэмээх Шагдарын Дамдины мэндэлсэний 150 жилийн ойн бүтээн байгуулалт, арга хэмжээнд хандивлах. Данс: ХААН банк 5466043925 ОНӨНҮҮГ /Орон нутгийн өмчийт нийтлэг үйлчилгээ, үйлдвэрийн газар/
- 3.12. Ашиглалт, эзэмшлийн ойролцоо байгаа малчин өрхийн хашаа хороог нүүлгэх, худаг усны асуудлыг шийдвэрлэхэд харилцан тохиролцож шаардагдах хөрөнгийн туслалцаа үзүүлж ажиллах

- 3.13. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөг холбогдох хууль тогтоомжийн дагуу батлуулж ажиллах
- 3.14. Олборлолтын үйл ажиллагааны явцад химиин хорт бодис хэрэглэх, хадгалах зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу авах
- 3.15. Олборлолтын үйл ажиллагааныхаа жилийн тайланг тухай бүр аймгийн Засаг даргын тамгын газар болон Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлж байх

#### **Дөрөв. Хамтран хүлээх үүрэг**

- 4.1. Талууд нь энэхүү гэрээний дагуу хүлээсэн тус тусын эрх, үүргээ гэрээ хүчинтэй байх бүхий л хугацаанд бүрэн хэрэгжүүлж, биелүүлэх
- 4.2. Гэрээний аль нэг тал нөгөө талын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй.
- 4.3. Хэрэв гэрээний аль нэг тал энэхүү Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах санал, хүснэгттэй бол энэ тухайгаа нөгөө талдаа 30 хоногийн өмнө бичгээр мэдэгдсэний үндсэн дээр харилцан тохиолцож шийдвэрлэнз.

#### **Тав. Гэрээг дүгнэх**

- 5.1. Энэхүү гэрээний биелэлтийг дараа жилийн эхний улиралд хоёр тал дүгнэж байна.

#### **Зургаа. Хариуцлага**

- 6.1. Компани энэхүү гэрээг зөрчсөн бол дараах арга хэмжээг зөрчлийн байдлаас хамааруулж, холбогдох хууль тогтоомжинд заасан эрх хэмжээнд авна.
- 6.1.1. Хууль болон гэрээ зөрчсөн үйлдлээ зогсоохыг Компаниас шаардах
- 6.1.2. Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, цуцлуулах хүснэгтээ эрх бүхий этгээдэд уламжлах
- 6.2. Энэ тохиолдолд компанийн шүүхэд гомдол, нэхэмжлэлээ гаргах эрх хэвээр хадгалагдана.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ДҮНДГОВЬ АЙМГИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ДҮНДГОВЬ АЙМГИЙН ХОХБТХ-ИЙН  
ДАРГА *Б.Дорж* Н.ЭРДЭНЭ-ОЧИР

Хаяг: Дундговь аймгийн  
Засаг даргын Тамгын газар  
Утас: 70592150  
91915480  
Факс: 70592150

УНАН АНД ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЗАХИРАЛ *Н.Тамжигсайхан* Т.ТӨМӨРСОЛЬ

Хаяг: Улаанбаатар хот СБ  
2-р хороо 32-96  
Утас: 88114980  
факс: 330104